

АНУ СУДЛАЛ БОЛ МОНГОЛЫН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ШИНЭ ЧИГЛЭЛ МӨН

Д.ШҮРХҮҮ*

Академич, профессор Ч.Далай гуай бол Монголын олон улсын харилцаа, гадаад орон судлалыг үүсгэн хөгжүүлэхэд, тухайлбал манай улсын хамгийн анхны олон улс судлалын мэргэжлийн байгууллага болох Дорнодахины судлалын хүрээлэн 1968 онд ШУА-ийн дэргэдэх Ази, Африкийн хэлтэс нэртэй байгуулагдах цагаас нь өнөөг хүртэл ажиллан хятад, япон, солонгос судлал болон Зүүн Хойт Ази судлалыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан билээ. Энэ талаар хурлын үндсэн илтгэлд болон үг хэлсэн хүмүүс ч нэлээд тодорхой ярьсан тул миний бие Ч.Далай гуайн ихээхэн анхааран цаашид хөгжүүлэхийг бодож явдаг манай орны олон улс судлалын шинэ чиглэл болж буй АНУ судлалын талаар товч ярихыг хичээе. Өнгөрсөн жил манай хүрээлэнгийн шинэ бүтэц зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэх үед Ч.Далай гуай Монгол улс хөрш хоёр их гүрэн ОХУ, БНХАУ-тай харилцах асуудлыг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл хэмээн чухалчлан үздэг тул манай хүрээлэн ч мөн адил орос судлал, хятад судлалын салбаруудтай байх нь зүй ёсны хэрэг юм. Үүний зэрэгцээ АНУ, Япон, Европын холбоо, Солонгос зэрэг стратегийн чухал ач холбогдол бүхий орнуудыг судлах бие даасан тасгуудыг байгуулах хэрэгтэй хэмээн онцлон тэмдэглэж байлаа.

Энэ дашрамд хэлэхэд манай нэрт түүхч, академич агсан Н.Ишжамц гуай Монголын АНУ судлалын төвийг олон жил тэргүүлэн Монгол улсад АНУ судлалыг үүсгэн хөгжүүлэхэд ихээхэн хичээл зүтгэл гаргасан төдийгүй Монгол, АНУ-ын харилцааны түүхийг хамгийн анх бичиж хэвлүүлснийг дурьдах нь зүйтэй хэмээн бодож байна. Эдүгээ академич Ч.Далай гуай Монголын АНУ судлалын төвийн тэргүүний үүрэг хүлээн ирэх оны 1-р сард тус төвийн 10 жилийн ойн үеэр АНУ-ын талтай хамтран хийх “ХХ зууны АНУ-ын ерөнхийлөгчид” эрдэм шинжилгээний бага хурлын бэлтгэл ажлыг удирдан зохион байгуулж байна.

1987 онд Монгол-Америкийн хооронд дипломат харилцаа тогтсон ба 1990 оноос Монгол оронд ардчилал, шинэчлэлийн үйл явц эхэлсэн нь Монгол-Америкийн харилцаа богино хугацаанд түргэн хөгжих таатай нөхцөлийг бүрэлдүүлсэн билээ.

* Д.Шүрхүү - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Америк, Европ судлалын тасгийн эрхлэгч, доктор (Ph.D)

Монгол Улс 1989-90 оны үеэс эхлэн ардчилал, шинэчлэлийн зам дээр гарч, АНУ зэрэг чөлөөт ертөнцийн улс орнуудтай харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагаа өрнүүлэх болсонтой уялдаж, тэдгээр орнуудыг биеэ даан судлах шаардлага гарч ирсэн юм.

1991 оны 1-р сарын 23-ны өдөр Монгол Улсын анхны Ерөнхийлөгч АНУ-ын Ерөнхийлөгчтэй Цагаан ордонд уулзсан цаг мөчийг тохиолдуулан ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн хэсэг эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан нарын санаачилгаар Монголын АНУ судлалын төв байгуулагдсан юм. Улс төр, үзэл суртлаас ангид, ашиг хонжооны биш, эрдэм судлалын олон нийтийн энэхүү байгууллагад тус хүрээлэнгийн 10 гаруй ажилтан, гаднын байгууллагуудын 30-аад ажилтан, янз бүрийн мэргэжлийн нийт 40-өөд хүн эвлэлдэн нэгдэж ажиллах болсон юм.

Төвийн гол зорилго нь Монголд өөрийн гэсэн америк судлалыг бий болгож хөгжүүлэх, үүний тулд нэн түрүүнд АНУ-ын өнөөгийн амьдрал, хөгжил, өнгөрсөн түүх, өвөрмөц соёл иргэншилтэй танилцаж, Монгол-Америкийн харилцаа, түүний ирээдүй төлөвийн асуудлыг анхааран судлах явдал байв. Түүнчлэн АНУ, бусад улс орнуудын америк судлалын ололт амжилт, өөрсдийн ажиглалт судалгаан дээр үндэслэн монгол түмэндээ АНУ-ын тухай аль болохоор тодорхой, зөв ойлголт олгох мэдээлэл, сурталчилгааны чиглэлтэй зорилт тавьж ажиллах явдал байв.

Дээрхи зорилтуудыг хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд АНУ-ын америк судлалын зарим байгууллага, ажилтан нартай холбоо тогтоож, Хятад, Солонгос зэрэг орнуудад зохиогдсон олон улсын америк судлалын хурал зөвлөлгөөнд оролцож, өөрийн төв дээр АНУ-ын холбогдолтой зарим семинар зохион байгуулж, АНУ-аас ирсэн эрдэмтэлтэй тогтмол уулзалт ярилцлага зохион байгуулж байлаа. Мөн тус улсад суугаа АНУ-ын элчин сайдын яам, түүний дэргэдэх АНУ-ын мэдээллийн албатай нягт харилцаа холбоо тогтоож, хамтран ажилласан нь тус төвийн судалгаа, сурталчилгааны ажил, мэдээллийн хангамж сэлтэд ихээхэн тус дөхөм болсоор ирэв.

Манай төвийн гишүүд 1991-1992 оноос эхлэн эрдэм шинжилгээ, сурталчилгааны сэтгүүл, сонин хэвлэлд АНУ-ын амьдрал, хөгжил түүний түүх, соёл, гадаад бодлого, Монгол-Америкийн харилцааны холбогдолтой өгүүлүүдийг нэлээд идэвхитэй бичиж нийтлүүлэх болсон юм. Америк тивийг Х.Колумб нээсний 500 жилийн ой, АНУ-ын сонгуулийн тогтолцоо, ардчилал, хүний эрхийн асуудлаар америк эрдэмтэн, мэргэжилтэн нарын оролцоо бүхий семинар, ярилцлага зохион байгуулж байв.

1994 оноос эхлэн Монголын АНУ судлалын төв нь “America: studies and information” хэмээх эрдэм шинжилгээ,

сурталчилгааны бэсрэгхэн сэтгүүл хэвлэх болсон. Түүний №2 нь 1996 онд, №3 нь өнгөрсөн 1998 онд гарсан. Сэтгүүлийн дугааруудал “АНУ бүрэлдэн тогтсон түүхээс” /С.Ишдорж/, “АНУ-ын төрийн тогтолцоо” /Д.Цолмон/, “Монгол дахь америк судлалын гараа” /Н.Ишжамц/, “Монгол-Америкийн өнөөгийн харилцаа” /Р.Отгон/, “АНУ дахь соёлын олон хэлбэрүүд” /Шерил А.Мартин/ зэрэг олон сонирхолтой өгүүлэл хэвлэгдсэн.

Тэргүүн зэргийн ач холбогдолтой бас нэг зорилт бол америк судлалын үндэсний шинэ залуу боловсон хүчин бэлтгэх, судлаачдыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх курст явуулж сурган далаггажуулах явдал байлаа. Монголын АНУ судлалын Төв нь их, дээд сургууль дээр америк судлалын анги, төвүүд шинээр байгуулагдаж, боловсон хүчин бэлдэх, шинжилгээ судалгаа хийхийг идэвхитэй дэмжсээр ирэв. Энэ хооронд Монгол улсын их сургуулийн дэргэдэх Олон улсын харилцааны дээд сургууль, Оттонтэнгэр их сургууль дээр америк судлалын хоёр төв, Хүмүүнлэгийн их сургууль дээр англи-америк судлалын анги тэнхимүүд нээгдэж, нэлээд оюутан сургаж байна.

1996 онд тус төвийн шугамаар Д.К.Стэвэнсоны “Америкийн нийгэм, амьдрал, заншил” /Штутгарт, 1987/ хэмээх 10 гаруй хэвлэлийн хуудас зохиолыг монголчилж, 1800 гаруй хувь хэвлэн нийтэлсэн нь монголчууд америк маягийн амьдрал, нийгэм, түүний мөн чанар өвөрмөц онцлогтой танилцахад чухал гарын авлага болсон юм.

Сүүлийн жилүүдэд АНУ-ын түүх, Монгол-Америкийн харилцааны чиглэлээр судалгааны тодорхой үр дүн, ном бүтээлүүд хэвлэгдэн гарав. 1999-2000 онд академич агсан Н.Ишжамц “АНУ-аас Монголд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа /1900-1987/”, доктор Д.Цолмон “АНУ-ын түүх”, доктор М.Хурметхан “Монгол, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа /1945-2000/ гэдэг номуудыг бичиж хэвлүүлэв. Манай Олон улс судлалын хүрээлэнгээс одоо хэрэгжүүлж буй “XX зууны сэргэн мандлын үеийн Монголын гадаад харилцаа”, “Монгол улсын үндэсний аюулгүй байдал ба гуравдахь түнш орнууд: өнөө үе, ирээдүй” хэмээх төслүүдэд америк судлалын зарим асуудлууд тусгагдан орсон билээ. 2000 оны 9-р сард Техникийн их сургуулийн улс төр судлалын багш Н.Галиймаа “XX зууны Монгол-Америкийн харилцааны зарим асуудлууд” сэдвээр дэд докторын зэрэг амжилттай хамгааллаа.

Түүнчлэн 1999 онд Олон улс судлалын хүрээлэн дээр Америк, Европ судлалын тасаг байгуулагдсан нь Монголын АНУ судлалын төвийн ажилд ихээхэн тус дэмжлэг болсон төдийгүй цаашид нягт харилцаа холбоотой хамтран ажиллах аятай нөхцөл бүрдүүлж байна.

АНУ-ын ЭСЯ-ны Мэдээллийн алба, Фулбрайтын сангийн дэмжлэг тусламжтайгаар 1997 онд “Америк судлал ба Монгол”, 1999 онд “Америкийн улс төр, соёл, мэдээлэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2 удаа зохион байгуулсан нь америк судлалын хөгжилд чухал хувь нэмэр болсон юм.

Монголчуудын өөрийн чармайлт, АНУ зэрэг гадаад улс орнуудын харилцаа холбоо, хамтын ажиллагаа, тусламж дэмжлэгт түшиглэн Монголд америк судлалыг үүсгэн хөгжүүлэх гэсэн амаргүй зорилт ямар нэг хэмжээгээр биелж байна хэмээн хэлэх байна.

Эдүгээ Монголын АНУ судлал үүсэн бүрэлдэх эхний үе шатнаас төлөвшин хөгжих дараагийн үе шатандаа дэвшин орж байгаа бөгөөд энэ үе шатны нэг онцлог бол цоо шинэ нөхцөл байдал, эрэлт шаардлага, зорилт дэвшигдэж байгаа явдал юм. Юуны өмнө Монгол-Америкийн харилцаа сүүлийн жилүүдэд бүхий л салбарт эрчимтэй хөгжих үндэс суурь тавигдаж байна. 1999 онд АНУ Конгресс Монгол улсад Худалдааны хэвийн нөхцөлийг байнга олгох шийдвэр гаргаж, мөн оны 7-р сард АНУ-ын ерөнхийлөгч Монгол улсыг Худалдааны хөнгөлөлтийн системд хамруулах шийдвэр гаргаснаар манай улсад худалдааны нэн тааламжтай нөхцөлийг олгож Монголын бүтээгдэхүүн ямарваа нэг тоон хязгаарлалтгүй болсон юм. 1999 оны байдлаар АНУ-тай хийсэн худалдаа Монгол улсын нийт гадаад худалдааны эргэлтийн 10 орчим хувийг эзэлж байна. АНУ-ын хөрөнгө оруулалттай 52 компани ноос, ноолуур, газрын тос, уул уурхай, оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Гэвч энэ бүхэн өнөөгийн шаардлага, бололцооноос нэлээд доогуур буйг хоёр тал цохон тэмдэглэж байгаа бөгөөд худалдааг өргөжүүлэх, шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн судалгаа тулгамдсан зорилт болоод байна. Саяхан эх орондоо буцсан элчин сайд А.Л.Порта хамгийн сүүлд манай улс төрчид, эрдэмтэдтэй хийсэн уулзалт дээрээ өөрийнхөө тооцоолсноор танай орон өмч хувьчлал, эрчим хүчний зохицуулалтад өөрчлөлт хийж чадаагүйгээс болоод бизнесийн уур амьсгалаа дордуулаад зогсоогүй 1 тэрбум орчмын долларын шинэ хөрөнгө оруулалтыг алдсан гэж хэлсэн нь нэгийг бодогдуулж байлаа.

Монгол улсын олон тулгуурт гадаад бодлогоос үүдэн гарч буй гуравдахь түнш орнуудтай харилцах зарчим, тэдний Монгол дахь ашиг сонирхлын судалгаа ч мөн ихээхэн чухал ач холбогдолтой асуудал гэдэг нь тодорхой. АНУ-ын шинэ элчин сайд Ж.Дингэр АНУ-ын Сенатын гадаад харилцааны хорооны хуралдаан дээр хэлсэн үгэндээ “Америкийн Монгол дахь гол сонирхол нь ардчилал, зах зээл дээр тулгуурласан эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино” гэжээ.

Өнөөгийн Монголын олон нийтийн АНУ-ын тухай мэдлэг, үзэл ойлголт, хандлага ч өдөр тутам авч буй мэдээллийн агуулгын төдийгүй, технологийн хувьд 10 жилийн өмнөхөөс эрс өөрчлөгдсөн байна. Ганцхан жишээ хэлэхэд, саяхан болж өнгөрсөн АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийг хэлж болно. Дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засаг, хамгийн ардчилсан улс төрийн тогтолцоотой АНУ ерөнхийлөгчөө хэрхэн сонгож буй үйл явцыг монголын ард түмэн дэлхийн олон зуун сая хүмүүсийн нэгэн адил ажиглан харж, өдөр тутам телевиз, радио, интернетээр шинэ шинэ мэдээлэл хүлээн авч байлаа. Үүнийг даган АНУ-ын улс төрийн тогтолцоо, ялангуяа сонгуулийн системийг ойлгох, судлах хүсэл сонирхол эрс нэмэгдэж байна. Мөн түүнчлэн америкийн ардчиллаас суралцах, зарим нааштай зүйлийг улс орондоо хэрэглэх явдал ч монголын нийгэмд бодит зүйл болж ирлээ. Тухайлбал, саяхан шинээр зохион байгуулагдсан Ардчилсан Намын зохион байгуулалт, үйл ажиллагаанд АНУ- улс төрийн намын тогтолцооны зарим элементүүд тусгагдан орсон юм.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Монголын Олон улс судлалын шинэ чиглэл болох АНУ судлал цаашид түүх, соёл, Монгол-Америкийн харилцаа төдийгөөр хязгаарлагдахгүй, улам төрөлжин, гүнзгийрэн хөгжих шинэ үе шат руу шилжин орж байна. Энэ үе шатны тавигдах зорилт, ажиллах арга барил судлагдахуун ч ихээхэн өөрчлөгдөн шинэчлэгдэх нь дамжиггүй.

Эцэст нь үе үеийн хятад судлаачдын болон олон судлалын чиглэлийн эрдэмтдийн багш, академич Ч.Далай гуайн 70 насны сүүдэр зэрэгцсэн билэгтэй сайхан энэ өдөр багшийнхаа тухай хэдэн үг хэлэх ховорхон боломж олдсонд нэн баяртай байгаагаа илэрхийлэхийн ялдамд номын их багш Таньдаа энх тунх урт удаан насалж, эрдэм номын ач буянаа олон мянган шавь нартаа түгээн явахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.